



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/440

Булган сум

Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх
тусгай зөвшөөрлийн тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 12 дугаар хэсгийн 12.13 хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам", Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаалаар батлагдсан "Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлага"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох цэгийн нэрийг 1 дүгээр, үйлчилгээний ангилал өөрчлөх цэгийн нэрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/445 дугаар захирамжийн Хутаг- Өндөр сумын С.Ганхуяг захиралтай "Өсөх тээсий" ХХК-ийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй "Тээсий" хүнсний дэлгүүртэй холбогдох заалтыг хүчингүйд тооцсугай.

3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-т заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга, Татварын газар (Д.Лхагвасүрэн), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга)-д тус тус даалгасугай.

4. Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Д.Алтаншагай), сумын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010183

Аймгийн Засаг даргын 2026 оны
 02 дугаар сарын 21-ны/ний өдрийн
 А/140 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭРС

Д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Булган сум 5-р баг, Магсаржав 2-р гудамж-217 тоот	"Сүлд халин булаг" ХХК	Ш.Долгормаа	"Баар"	"Халин булаг"
2	Рашаант сум 2-р баг, Найрамдал хороолол 2-206 тоот	"Гурванхан Од" ХХК	Д.Мөнхжаргал	Хүнсний дэлгүүр	"Жаргалант маркет"
	Нийт-2				



Аймгийн Засаг даргын 2026 оны
02 дугаар сарын 24-ний өдрийн
Х/А/10 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АНГИЛАЛ ӨӨРЧЛӨХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖ

Д/д	Сумын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч			Үйлчилгээний ангилал	Оноосон нэр	Шинээр тусгай зөвшөөрөл эзэмших		Оноосон нэр
		Аж ахуйн нэгжийн нэр	Захирлын овог, нэр	4			Аж ахуйн нэгжийн нэр, албан ёсны хаяг	7	
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Хутаг-Өндөр сумын 1-баг, Магсаржав гудамж 1-138 тоот Нийт-1	"Өсөх тээс" ХХК	С.Ганхуяг	Хүнсний дэлгүүр	"Тээсий"	Хутаг-Өндөр сумын 1-баг, Магсаржав гудамж 1-138 тоот	"Караоке баар"	"Тээсий"	